


Төмөр-Очирын Батбаяр[✉]

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайваны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Монголын археологийн дурсгалаас олдсон хөгжмийн зэмсгүүд

Хураангуй. Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулсан археологийн судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд, хөгжмийн зэмсэгтэй холбогдож болох сэдэв агууламж бүхий хадны сүг зургуудыг хэд хэдэн газраас илрүүлж олсон бөгөөд он цагийн хувьд шинэ чулуун зэвсгийн үеэс хүрлийн үед хамааруулан үзсэн байдаг. Харин археологийн малтлага судалгаагаар хөгжмийн зэмсэгтэй холбогдох олдворын зүйл цөөнгүй олдсон нь сонирхолтой юм. Тухайлбал: Хүрэл зэвсгийн үед холбогдох 2 ясан шүгэл, Хүннү хэл хуур, Түрэгийн босоо ятга, Уйгурын хүрэл хонх, Монголын эзэнт гүрний үеийн ясан шүгэл, их бага хүрэл хонхнууд зэрэг Монголын эртний түүхэн үеүдэд холбогдох хэдэн зүйлийн хөгжмийн зэмсэг илэрч олдсон байна. Манай улсын археологийн дурсгалаас олдсон эдгээр хөгжмийн зэмсгийн холбогдолт олдворууд нь одоогийн монгол нутагт оршин тогтнож явсан эртний нүүдэлчдийн оюуны соёлын хөгжлийг илтгэн харуулахын зэрэгцээ хөгжмийн зэмсгийн төрөл зүйл, түүхэн уламжлал, хөгжлийг гэрчлэн харуулах биет баримт хэрэглэгдэхүүн болох нь илэрхий байна.

Түлхүүр үг: Нүүдэлчдийн хөгжим, ясан шүгэл, хэл хуур, босоо ятга, хүрэл хонх




Зураг 1. Эртний хөгжмийн зэмсэг олдсон дурсгалт газруудын байршил

Монгол нутгийн хадны сүг зураг бол шууд бусаар боловч хөгжмийн зэмсгийн үүсэл хөгжлийн хамгийн эртний баримтын нэг юм. Монгол орон эртний хадны сүг зургаар баялаг бөгөөд түүний нэг гол төлөөлөл байгалийн будаг зосоор зурсан зургийг дээд палеолитын үеэс бүтээх болсныг судлаачид олон жилийн судалгааны үр дүнд тогтоосон байдаг (Зураг 1). Харин баяр ёслол, бүжиг наадам, хөгжмийн зэмсэгтэй холбогдож болох сэдэв агууламжтай зургийн ихэнх нь неолитын үеэс хүрлийн үе хүртэлх хугацаанд хамаарах дурсгалууд ажээ.

Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг Зураагийн Улаан хаднаас өгүүлэн буй сэдэвт холбогдуулж болох улаан зосоор зурсан нэн эртний зосон зураг олдсон байна (Цэвээндорж 1977, 29-38). Энэ зургийн дотор дээшээ харсан ац, хоёр гараа унжуулан зогссон хүн, цээж биеийг нь гурвалжин дүрсээр гаргасан зэрэгцэн зогсож байгаа 2 хүн, тэдний ойролцоо дээш өргөсөн хоёр гарынхаа

нэгэнд цагариг барьж салаа оройтой малгай өмсөөд бүжиж дэвж буй мэт хоёр хүнийг дүрсэлсэн байжээ. Мөн зургийн төв дунд хоёр салаа оройтой малгай өмсөж дээш өргөсөн хоёр гарынхаа нэгд цагариг бариад зогсож буй хүн түүний зүүн хажууд цээжийг нь гурвалжин дүрсээр гаргасан урт хормойтой хувцас өмссөн хүн зурсан бөгөөд дээрх хоёр хүнийг бүсэлхий орчмоор холбосон байна. Тэдний хажууд “х” тэмдэг, хоёр гараа дээр өргөн цагариг барьж, хөлөө нугалан бүжиглэж буй бололтой хүнийг зурсан байдаг. Уг зурагт дүрслэгдсэн гар өргөн цагариг мэт зүйл барьж, бүжиглэн буй бололтой зургийг анхлан судалсан Академич Д.Цэвээндорж бүс нутгийн хэмжээнд харьцуулан үзсэний үндсэнд, хэнгэрэг дэлдэн бөөлж байгаа бөөг зурсан бололтой хэмээн үзжээ (Мөн тэнд, 33). Энэ төрлийн зураг Өвөрхангай Дэлгэрэх сумын Баян улаан уул, Уянга сумын Шурангын бичигт улаан хад, Төв аймгийн Зуун мод, Баян-Өнжүүл сумын Зоргол хайрхан уул зэрэг газраас олдсон байна.



Зураг 2. Булган аймаг, Орхон сум, Неолитын үед холбогдох зосон зургийн хуулбар



Зураг 3. Өвөрхангай аймаг, Батширээт сум, Тэмээн чулууны амны дөрвөлжин булшны хашлага чулууны хэв хуулга

Дараагийн нэг баримт бол Хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булшны хашлага чулуу болон энэ үеийн хадны зурагт тохиолддог зэрэгцэж эгнэсэн байдалтайгаар зогссон олон хүний өвөрмөц дүрслэл юм (Зураг 2). Манай улсын Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уул, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Тэмээн чулууны ам (Зураг 3), Хэнтий аймгийн Батширээт сумын Дуган хад, Дорноговь аймгийн Мандах сумын Номт, Өмнөговь аймгийн Ноён сумын Хиагт (Зураг 4) зэрэг газраас ийм сэдэв, зохиомж бүхий зургийг судлаачид илрүүлэн олжээ. Эдгээр зургийн хамгийн нийтлэг шинж нь хүмүүс хоорондоо хөтлөлцсөн, гар гараасаа барилцсан, өрөөсөн гараа өргөөд эгнэж зогссон, гартаа ямар нэгэн эдлэл бариад зэрэгцэн зогссон, гараа солбин өргөж эгнэсэн зэрэг олноор цуглан хийж гүйцэтгэдэг ёслол, зан үйлийг үзүүлсэн байдаг аж (Батболд 2014, 66). Хадны зургийн зарим судлаачдын таамаглаж байгаачлан, эдгээр зурагт буй гар гараа барилцан байгаагаар дүрслэгдсэн хүмүүсийг бүжиглэн (Цэрэндагва 2017, 101) буй, нэг гартаа ямар нэгэн эдлэл барьж хөдөлгөөнт байдлаар дүрслэгдсэн хүмүүсийг нэгэн зүйлийн хөгжмийн зэмсэг хэц, хэнгэрэг барьсан

бүжигчин (Новгородова 1989, 253) хэмээн үзсэн нь сонирхолтой байна.

Өнөөгийн Монгол Улсын хил хязгаарын хүрэн дотор хийгдсэн археологийн малтлага судалгааны үр дүнгээс үзэхэд, Хүрэл зэвсгийн хожуу үед хамаарах нэгэн чулуун байгууламжаас тухайн үеийн ясан шүгэл илэрч олдсон нь одоогоор манай улсын нутгаас археологийн малтлага судалгаагаар



Зураг 4. Хүрэл зэвсгийн үеийн хадны сүг зураг. Өмнөговь аймаг, Ноён сум, Хиагт

илрүүлсэн хамгийн эрт үед холбогдох хөгжмийн зэмсгийн биет баримт хэмээн үзэж болох юм. Уг зэмсгийг 2018 онд Монгол-Америкийн хамтарсан “Баруун Монгол” төслийн хүрээнд Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг Замбага хайрханд малтсан 20х18 м хэмжээтэй, дугуй хэлбэртэй намхандуу чулуун овоолготой, хүрээгээр нь тойруулан дунджаар 1 м орчим өндөр, хавтгай чулуудыг хавиргалан босгож дугуй хүрээ үйлдсэн тахилын байгууламжаас илрүүлэн олжээ (Баяндэлгэр нар 2022, 36-43).

Уг олдвор нь мал, амьтны шагайт чөмгөний хоёр үзүүрийг тэгш огтоолж, бүдүүн үзүүрийн ирмэг дээр доош харсан трапец хэлбэртэй хоног гаргаж цоолсон гуурсан хэлбэртэй. Ясан эдлэлийн гадна талд зарим хэсгээр мөлийж элэгдсэн. Бүдүүн талдаа ялимгүй ээтэн хэлбэртэй. Урт 11,09 см, өргөн 2 см, зузаан 1,75 см. Ясан гуурсны нэг талыг бөглөж нөгөө талаас нь үлээж хийн урсгал үүсгэхэд агаарын хүчтэй урсгалын тусламжтай хэлбэлзэл үүсгэж чанга дуу авиа гаргах боломжтой бүтэцтэй болохыг судлаачид магадалжээ (Зураг 5). Хөгжмийн зэмсэг олдсон Замбага хайрхны уг дурсгалаас гарсан нохойны эрүүний ясанд нарийвчилсан он цаг тогтоолгоход НТӨ 1042±31 он гэсэн үнэмлэхүй он цаг гарсан нь Хүрэл зэвсгийн хожуу үед хамаарах юм.



Зураг 5. Хүрэл зэвсгийн үеийн ясан шүгэл.
Увс аймаг, Зүүнхангай сум, Замбага хайрхан

Замбага хайрхны Хүрэл зэвсгийн үеийн тахилын байгууламжаас гадна энэ үеийн оршуулгын дурсгал болох булшнаас ясан шүгэл олдсон баримт бас бий. 2011 онд археологич доктор А.Энхтөрийн удирдсан ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн авран хамгаалах хээрийн шинжилгээний анги Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Уньт багаас Хөвсгөл аймгийн Тариалан сумын чиглэлд шинээр тавих авто замын дагууд өртсөн чулуун зэвсгийн суурин газар 1, хиргисүүр 4, 36 булш малтан шинжилжээ. Эдгээрээс Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уньт багаас хойд зүгт 22 км

зайд, Төлбөрийн голын баруун талын Шөвгийн үзүүр хэмээх газарт орших 4-р хиргисүүр хэмээн тус экспедиц баримтжуулсан, 6х8 м хэмжээ бүхий 4 буландаа хөшөө чулуутай дөрвөлжин хэлбэрийн битүү чулуун дараастай нэгэн булшинд хүний оршуулгын цээжин хэсгийн ясан дээрээс 2х5 см орчим хэмжээтэй өвөрмөц хийцтэй ясан эдлэл гарсныг шүгэл (Зураг 6) хэмээн үзсэн байдаг (Энхтөр нар 2011). Уг булшны хүний оршуулга 90 см гүнээс илэрсэн нь цээжин хэсэг хөндөгдөж эмх цэгцгүй болж, харин аарцаг болон хоёр хөлийн яс огт хөндөгдөөгүй анх тавьснаар байжээ. Булшны нүхний чиглэл, хүний оршуулгын тавилт зэргээс үндэслэж талийгаачийг чанх зүүн зүгт хандуулан тавьсан болохыг тодруулсан аж. Олдворын хувьд оршуулгын түвшинд ясан шүглээс өөр зүйл гараагүй байна.



Зураг 6. Хүрэл зэвсгийн үеийн ясан шүгэл.
Булган аймаг, Хутаг-Өндөр сум, Төлбөрийн гол

Шөвгийн үзүүрийн энэ булш нь газар зүйн байршлын хувьд уулын өвөр бэлд, голын дэнж дээр байрласан, дөрвөн буланд хөшөө бүхий дөрвөлжин дараастай, булшны нүхийг чанх баруун зүүн чиглэлтэй ухаад түүний дотор талийгаачийг зүүн зүгт хандуулан тэнэгэр байдалтай хэвтүүлж, хоёр хөлийг жийлгэж оршуулсан, оршуулгын нүхийг том хавтгай чулуудаар тагласан зэрэг булшны байршил, гадаад дотоод байгууламж, оршуулгын зан үйлийн онцлог шинжээрээ Монгол болон Өвөр Байгалийн нутагт олон тоогоор малтан шинжилсэн Хүрлийн дунд ба хожуу үеийн булштай адил төстэй болох нь илэрхий байна.

Археологийн малтлага судалгаагаар Хүрэл зэвсгийн үеийн булш оршуулга, тахилын байгууламжаас илрүүлсэн эдгээр ясан шүглээс гадна түүврээр олдсон нэгэн ховор олдворыг судлаачид энэ үеийн хөгжмийн зэмсэг хэмээн үзсэн нь сонирхолтой байна. Энэ бол аргалийн дүрстэй хүрэл эдлэл бөгөөд Архангай аймгийн Хашаат сумын нэгэн иргэнд өвөг дээдсээс нь уламжлагдан ирж хадгалагдаж байсныг академич Д.Цэвээндорж анх сурвалжлан судалгааны эргэлтэд оруулсан байдаг.

Энэхүү эдлэл нь үзүүртээ бүтэн баримлаар урласан аргалийн толгой, хүзүүний дүрстэй

бөгөөд түүний нүд, хамрыг дугуй товгор хүрээгээр илэрхийлж, урагш ялимгүй налуу шовх навчин хэлбэрийн чихийг ар тийш махиралдсан эвэрт нь хүргэн дүрсэлсэн байжээ. Аргалийн толгойг дүрсэлсэн хэв маяг нь Өмнөговь аймгийн нутгаас олдсон хүрэл хутга, чинжаалуудын тольт, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уулын Хүрэл зэвсгийн дөрвөлжин булшнаас гарсан хос алтан сүлбээр, Дүрслэх урлагийн музейд хадгалагдаж буй хүрэл шорны толгой дахь аргалийн дүрсүүдтэй ижил байгаагаас нь үндэслэж он цагийн хувьд Хүрэл зэвсгийн үед МЭӨ 1200-800 жилд холбогдох бололтой гэж үзээд уг эдлэл дээрх аргалийн дүрсний хоёр хажууд нь гурав гурав нийт зургаан товх буй нь ерөнхий төрхөөрөө морин хуурын болон мандалин, гитар хөгжмийн утас уяж чангалдаг чихийг санагдуулна. Хүрэл эдлэлийн бодит хэмжээ, түүний хэлбэр хийц нь үнэхээр хөгжмийн зэмсгийн толгой, чих байж болох бүрэн бололцоотой. Хэрвээ энэхүү эдлэлийн зориулалтын тухай бидний таамаглал үнэн бол Хүрэл зэвсгийн үед монгол нутагт амьдарч байсан эртний овог аймгийнхан зургаан утастай (морин хуур шиг хялгастай) хөгжмийн зэмсэг хэрэглэж байжээ гэж үзэж болмоор байна хэмээн тэмдэглэжээ (Цэвээндорж 2003, 52). Гэвч одоогоор энэ нь таамаглал төдий бөгөөд цаашид энэ талаар гүнзгийрүүлэн судлах шаардлага бий.

1989 онд Д.Цэвээндорж, Унгарын эрдэмтэн И.Эрдели нарын удирдсан “Хүннүгийн дурсгал судлах шинжилгээний анги” Монголын төв хэсэг болох Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Туул голын хойд хөндийд орших Морин толгой хэмээх ууланд малтан шинжилсэн 1-р хүннү булшнаас ясан хэл хуур илрүүлсэн нь Монгол улсын нутаг дэвсгэрээс олдсон өвөг монголчуудын хөгжмийн зэмсгийн цорын ганц биет баримт болохын хувьд энэ үеийн хөгжмийн судалгаанд онцгой байр суурь эзэлдэг. Энэхүү хөгжмийн зэмсэг нь 12,5 см урт, 1,4 см өргөн, 2 мм зузаан хэмжээтэй. Хийцийн хувьд 9,7 см урт, угаараа 5 мм, үзүүрээрээ 4 мм өргөн хэмжээтэй ганц урт хэлтэй (Зураг 7). Хэлний уган талд ганц жижиг нэвт нүхтэй бөгөөд түүний эсрэг талын хоёр хажууг гадна хоёр талаас нь хүнхийлгэн зорж бариул гаргасан нь сүвлэж утсан татлага хийж

байсны гэрч юм (Цэвээндорж 2003, 293-301).

Морин толгойн хэл хуурыг анх судалж нийтэлсэн эрдэмтэн бол академич Д.Цэвээндорж бөгөөд цаашид энэхүү олдворын судалгаанд Унгарын эрдэмтэн И.Эрдели, Монголын эрдэмтэн З.Батсайхан, Ц.Төрбат нар өөр өөрийн хувь нэмрийг оруулан судалж ирсний дүнд ийм хийц бүтэцтэй хэл хуур Хүрлийн үеэс Хүннүгийн үеэр дамжин Хүннүгийн хожуу үед хамаарх Монгол, Умард Хятад, Өвөр Монгол, Тува, Минусын хотгороос археологийн малтлагаар одоог хүртэл 10 орчим илэрч олдсон болохыг харьцуулсан судалгаагаар тогтоосон байна (Төрбат 2017, 169-180).

Уг хэл хуурыг 50 гаруй настай эрэгтэй хүний шарилын зүүн гарын сарвууны доор тавьсан байжээ. Үүнээс гадна энэ булшнаас шавар ваарын хагархай, хонины эвэртэй толгой, хүзүүний яс, төмөр утсан сэнж бүхий богийн шагай, хүний баруун хөлийн дунд чөмгөний орчмоос зэвэрч муудсан цагариган сэнжтэй төмөр хутга, ширэн хуйны тасархай, бүсэлхий орчмоос бүсний төмөр арал, товруу чимэглэлийн үлдэгдэл, нурууны доороос бугын эврээр хийсэн жижиг ясан сав зэрэг эд өлгийн зүйл гарсан нь аль ч газрын хүннүгийн булшнаас элбэг тохиолддог бөгөөд мэргэжлийн судлаач археологичдын хувьд хүннүгийнх гэдэг нь нэгэнт маргаангүй тогтоосон зүйл аж (Цэвээндорж 2003, 293-301).

Археологийн малтлага судалгаагаар дээр өгүүлсэн хэл хуураас өөр хөгжмийн зэмсэг гэж баттай үзэх эд өлгийн зүйл олноогүй боловч хүннү булшнаас цөөнгүй гардаг, ясаар хийсэн 3 см орчим урттай, нэг этгээдийг нь ташуулан зорж зассан ясан эдлэл болон 7-9 см урт ясан хонгио зэргийг археологич З.Батсайхан бишгүүрийн бурзан буюу амгайвч байж болох таамаглал дэвшүүлсэн юм. Ийм эд зүйлийг судлаачид “адууны тоног хэрэглэл”, “гоёл чимэглэл” хэмээн ерөнхийлөн нэрлэж ирсэн боловч түүнийхээр зан үйлийн холбогдолтой эдлэл байж магадгүйгээс гадна их төлөв эрэгтэй хүний булшинд зэр зэвсгийн хамт дагуулан тавьсан байдаг аж. Мөн уг олдворын хэлбэр, хэмжээ, хийцийн онцлогийн зэрэгцээ бишгүүрийг эрэгтэй хүний хөгжим гэж үзэх явдал байдгийг дурдсан байдаг (Батсайхан 2002, 119-120).



Зураг 7. Хүннүгийн хэл хуур. Төв аймаг, Алтанбулаг сум



Зураг 8. Түрэгийн үе хөгжмийн зэмсэг. Ховд аймаг, Манхан сум

Ховд аймгийн Манхан сумын Жаргалант Хайрхан уулын Нүхэн хадны оршуулгаас 2008 онд зохиогчийн оролцсон шинжилгээний ангийн илрүүлсэн түрүү дундад зууны эртний нүүдэлчин дайчны оршуулгаас тухайн үеийн морьтон дайчин эрд байж болох бүрэн өвч хэрэгсэл, зэр зэвсэг зэрэг олон тооны маш сайн хадгалалттай эд өлгийн зүйлс гарсны дотор хамгийн санаанд оромгүй гайхамшигтай зүйл гарсан нь модоор урласан морин толгойтой хөгжийн зэмсэг байсан юм (Зураг 8). Хэдийгээр уг оршуулгаас гарсан бараг бүх зүйл сайн хадгалалттай байсныхаа хувьд ховор нандин бөгөөд археологийн чухал олдворын тоонд орох боловч чухам энэ хөгжмийн зэмсэг гарснаар л уг малтлагыг археологийн томоохон нээлтийн хэмжээнд хүргэсэн онцгой ховор нандин эдлэл мөн билээ.

Жаргалант Хайрхан уулын хадны оршуулгын хэрэглэгдэхүүн эртний Түрэгийн үеийн нүүдэлчдийн булшнаас гардаг эдийн зүйлстэй ижил төслөг, түүний дотор оршуулгад дагалдуулдаг байсан, тухайн үеийн стандарт болсон зууван сэнжтэй дөрөө, дугуй бүүрэгтэй, уужим суудалтай эмээл, ясан арал, хөө хуягийн ялтас, багц сумтай үйсэн хоромсого, нум, хусны үйсээр хийсэн саадаг, түүний тоног чимэглэлүүд, төмөр хутга, бүсний дөрвөлжин товруун чимэг, амтай хүрэл гархи зэрэг зүйлүүд нь уг дурсгал эртний Түрэгийн үед холбогдохыг нотолж өгсөн юм. Нэн ялангуяа руни бичээс болон сийлмэл зурагтай хөгжмийн зэмсэг (Зураг 9) нь энэ дурсгал HT VI-VIII зуунд



Зураг 9. Жаргалант хайрханы хөгжмийн зэмсэг, царын ард байх сийлмэл зураг

холбогдохыг баттай харуулсан болно (Төрбат нар 2008, 279). Уг булшнаас гарсан хоромсогоос авсан дээжид хийсэн радиокарбоны шинжилгээгээр НТ 590-670 он гэсэн үнэмлэхүй он цаг гарсан (Bemmann 2012, 380) нь харьцангуй хугацаатай явцав тохирсон юм.

Евразийн хэмжээнд археологийн малтлага, тэр дундаа булш оршуулгын малтлагаас модон хөгжмийн зэмсэг гарсан тохиолдол нэн ховор байдаг. Харин төрөл бүрийн төмөрлөг болон яс, чулуун хөгжмийн зэмсгүүд цөөнгүй гарч хүн төрөлхтний эртний хөгжмийн урлагийн өв сан улам бүр баяжсаар байгааг бид мэднэ. Тухайлбал, манай улсаас урьд өмнө Хүннүгийн үеийн жирийн иргэдийн булшнаас ясан хэл хуур илэрч байсан түүхтэй болохыг дээр нэгэнт өгүүлсэн билээ.


Монголын археологич, түрэг судлаач, хөгжим судлаачдын хамтын хүчээр хийсэн судалгааны үр дүнд уг хөгжмийн зэмсгийн төрөл зүйл, уг нэр, эзэмшигчийнх нь нэр алдар, унаган дуугаралт хөг аялгууг нь хүртэл сэргээж чадсан байна. Евразийн хүрээнд хийсэн харьцуулсан судалгааны үр дүнд Жаргалант хайрханы хөгжмийн зэмсгийн эртний нүүдэлчдийн хөгжмийн соёл дахь байр суурийг тодруулж, түүний онцгой ач холбогдлыг илрүүлэн тодорхойлсон юм.

Уг хөгжмийн зэмсэг нь морины толгойн дүртэй урт нумарсан хүзүү бүхий цар, царыг таглах тусгай хавтсан таг гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэж байна. Үүний их биеийг хус модоор элдэв залгаа, наалт үгүй урлажээ. Харин царын таг бас тээгийг уд модоор хийсэн байна. Эх биеэс хүзүүг бага зэрэг доош налуулан зорж аажмаар өгсүүлэн 40 хэм өнцөгтэй налуулан хийж үзүүрт нь адууны толгойг сийлжээ. Адууны хоншоор шөмбөгөр, бага зэрэг хөхөлтэй ба дагзан дээр дөрвөлжин хэлбэрийн нүх гаргасан нь чавхдасыг тогтоох зориулалт бүхий босоо гарыг суулгах үүрэгтэй юм. Ерөнхий өндөр 12,7 см, өргөн 10,4 см, 72,3 см урт хэмжээтэй.

Зэмсгийн цар нь хоёр үзүүр лүүгээ огцом нарийссан урт гонзгой, голдоо хөндий, завь мэт хэлбэртэй. Царны гадна ёроолын төв дунд хэрээс хэлбэртэй нэвт нүх гаргаж, нарийн зураасаар хөвөөлөөд үүний эргэн тойрны бүх талбайг эзлүүлж хүн ба амьтад бүхий ан авын зохиомжит зургийг хажуугаас харсан байдлаар хурц үзүүртэй багажаар хонхойлгон ухаж дүрсэлжээ. Чимэглэл зурагт зургаан буга, нэг янгир, дөрвөн нохой, нум барьсан нэг анчин бий. Бугын эврийн олон салаа, нум сум харвахаар эхэж буй гөрөөчний харвуулын сумны зэвийг хүртэл нарийн зураасаар тодорхой дүрсэлсэн үзэгдэнэ (Зураг 10).

Зэмсгийн хүзүүг нь царны их биеэс шууд гаргаж хийгээд бүхэлд нь одоо гялалзсан хар өнгөтэй харагдах хусны үйсээр ороож хулдаж байсны үлдэгдэл зурвас байдалтай хадгалагджээ. Энэхүү

үйсэн гадар ихэд хатаж, ховхрон үгүй болсны улмаас доор нь байсан эртний түрэг бичээс ил болжээ. Зэмсгийн хүзүүний баруун зүүн, аль аль талд хурц үзүүртэй багажаар сараачиж бичсэн тус бичээс байхын зэрэгцээ царны хоёр талын хөвөөнд хурц зүйлээр ухаж, сараачиж бичсэн өөр бас түрэг бичээс бий.



Зураг 10. Жаргалант хайрханы хөгжмийн зэмсгийн царын сийлмэл зургийн хуулбар

Царын хүзүүний төгсгөлд буюу морины толгойн ар шилэнд тэгш өнцөгт хэлбэртэй нэвт цоорхой нүх байх ба энэхүү нүхийг хажуугаас морины чихний яг доод талаас хөндлөн цоолж өөр нэг жижигхэн нүх гаргажээ. Эдгээр нүхнүүд нь ямар нэгэн зүйлийг углуургадаж бэхлэхэд зориулсан бололтой.

Энэхүү хөгжмийн зэмсгийн цар нь тусгай тагтай бөгөөд түүнийг нимгэн хавтгай модоор царны ерөнхий хэлбэрт тааруулж үйлджээ. Таг нь голдоо трапец хэлбэрийн тэвхтэй. Энэ нь гол тэнхлэгийн дагууд байрласан байх бөгөөд оройн хэсэг нь хугарч үгүй болсон. Хугарсан хэсэгт хооронд нь адилхан зайтайгаар гаргасан чавхдасны гурван нүх байх бөгөөд эдгээрийн хамгийн дээд талын нүх

яг хугарсан хэсгийн ирмэгт таарсан ажээ. Царын дотор талын хананд цилиндр хэлбэрийн жижигхэн модон товх наалттай байсан нь хожим ховхрон унасан байна. Тэвхний ойролцоо таганд нэг нүх буй нь модны ярных бололтой. Мөн түүнчлэн цар хүзүү хоёрын уулзвар хэсэгт нэг, царын нэг талын ирмэгт өөр бас нэг нүх бий.



Зураг 11. Жаргалант хайрханы хөгжмийн зэмсгийг Германы эрдэмтэн С.Шульц сэргээсэн байдал.

Германы эрдэмтэн Сюзанна Шульц уг хөгжмийн зэмсгийг хөгжим судлалын үүднээс судлахын зэрэгцээ өөрийн сэргээлтийн ихээхэн сонирхолтой хувилбарыг бодит байдлаар хийсэн билээ (Зураг 11). Түүний үзэж байгаагаар Жаргалант хайрханы хөгжмийн зэмсэг бол өнцөгт босоо ятга (Winkelharpe) болох юм (Shulz 2012, 147). Харин Монголын хөгжмийн зохиолч Д.Ганпүрэв уг зэмсгийг нумлаг буюу нуман ятга (Ганпүрэв 2014, 189) гэж үзсэний зэрэгцээ мөн л өөрийн сэргээлтийг хийж бодитоор урласан төдийгүй тусгай хөгжмийн зохиол туурвиж, сэргээсэн хөгжмөөрөө амжилттай тоглож байгаа билээ.

Жаргалант хайрханы босоо ятгын царын ар талд баялаг өгүүлэмжтэй сийлмэл зураг бий. Энд буга, 1 янгир, 5 нохой болон нум татаж харвах гэж байгаа нэгэн анчны дүрсийг сийлжээ. Эдгээр дүрслэл гурван өөр үед дэс дараатай сийлэгдсэн бололтой. Уг зургийг судалсан профессор Э.Якобсон-Тепфер мөн л гурван цаг үед сийлсэн байна гэж үзсэн байдаг (Jacobson-Tepfer 2012, 158).

Жаргалант хайрханы хөгжмийн зэмсгийг эзнийх нь толгой талд хүндэтгэлтэйгээр дагалдуулан тавьсан байжээ. Уг зэмсгийг эзэмшигч цэл залуу баатар эрийн оршуулгыг нум сум, эмээл, дөрөө, агсарга бүс зэрэг тухайн үеийн нүүдэлчин дайчны хэв шинжит эдлэл хэрэгсэл дагалдсан байхын зэрэгцээ 4 ширхэг хуягийн ялтас илэрсэн нь чухамдаа дайчин баатар эр байсныг давхар батлах юм. Гэхдээ жирийн нэг дайчин биш бас хөгжимчин, магадгүй туульч эр байсан бололтой.

Уг хөгжмийн зэмсэг нь бусад төрлийн босоо ятгатай харьцуулахад жижиг, авсаархан тул нүүдлийн амьдралын хэв маягт тохирсон, морины нуруун дээр ч тоглох бололцоотой нь үнэхээр Монголын тал нутагт зохицсон хөгжим юм. Жаргалант хайрханы хөгжмийн зэмсэг биеийн ерөнхий хэлбэрээр Евразийн хэмжээнд археологийн судалгаанаас олдсон бусад бүх олдвороос эрс ялгарахын зэрэгцээ морин толгой, руни бичээс, сийлмэл зураг зэргээрээ утга соёлын ач холбогдол нь хол давуу билээ.

Уг хөгжмийн зэмсгийн хажуу бөөр, хүзүүний дагуу 6 хэсэг газарт эртний түрэг хэлээр руни бичгээр сийлсэн бичээс байгаа нь уг олдворыг шууд археологийн онцгой, нэн ховор зүйл болгож байна. Монголын түрэг судлаач, профессор Ц.Баттулгын уншиж тайлснаар бол уг хөгжмийг эртний түрэг хэлээр *Яаялиг* (монгол хэлээр - Аялгуут) хэмээн нэрлэж байжээ. Харин хөгжмийн зэмсгийг эзэмшиж байсан баатар эрийг Чүрэ гэдэг байжээ. Магадгүй түүний олонд түгсэн алдар цуу нь “*Яая-Огыл*” буюу “Аялгууч хүү” байсан бололтой (Баттулга 2014, 174-176). Ийнхүү хөгжмийн зэмсэг маань өөрийн нэрийг, өөрийн эзний нэрийг алдар цуутай нь хамт хэлж өгсөн нь үнэхээр ховор гайхамшигт тохиолдол мөн билээ.

Архангай аймгийн Хотонт сумын нутаг Орхон голын хөвөөнд орших VIII-IX зууны Уйгурын нийслэл Ордубалык буюу Хар балгасын Ордон хотын худгийг Монгол-Германы хамтарсан Орхон экспедиц 2018 онд малтан судлах явцад дотроос нь олон төрөл зүйлийн эд өлгийн зүйлс илэрч олдсоны дотор нангиад бичээстэй хүрэл хонх байсан (Зураг 13) нь Уйгурын хот суурины дурсгалаас урьд өмнө илэрч байгаагүй шинэ эх хэрэглэгдэхүүн төдийгүй тухайн үеийн нэгэн зүйл хөгжмийн зэмсгийн гэрч баримт болох юм (Эрдэнэбат, Батбаяр 2019).

Уг хонх хоёр талдаа тус бүр дөрвөн нангиад үсэгтэй. Зарим судлаач урьдчилсан байдлаар, нэг талын бичээсийг “Найман хөгжим зургаан эрдэм” юм уу эсвэл “Найман өлзий зургаан эрдэм”, нөгөө талын мөрийг “Дээр арван тэнгэрт хүрмүй” хэмээн тус тус монгол хэлнээ утгачлан орчуулсан байна. Тус бичээс нь хонхноос гарах хөг аялгууг магтан дуулсан ерөөл бэлгэдэл үгийн шинжтэй болох нь илэрхий ажээ.

Энэхүү хонх нь хүрлээр цутгасан их бие болон сэнж, төмөр хэл гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Их бие нь хоёр талдаа дээр өгүүлсэн нангиад бичээсээс гадна тэдгээрийн хоёр талаар тус бүр өөд өөдөөс харсан байдалтай хоёр хос үүлэн хээтэй. Бүх жин нь 2700 грамм. Нийт өндөр 25 см. Их биеийн тойрог нь хамгийн өргөн суурийн хэсэгт 13 см, зузаан нь 1 см байжээ (Эрдэнэбат нар 2019, 254-260).




Зураг 12. Сяньбигийн үеийн хүрэл хонх.
Орхон аймаг, Жаргалант сум, Айрагийн гозгор



Зураг 13. Уйгурын үеийн хүрэл хонх.
Архангай аймаг, Хотонт сум, Хар балгас

Монголын эзэнт гүрний үеийн хөгжмийн зэмсэгтэй холбогдох биет олдвор хэрэглэгдэхүүн археологийн судалгааны үр дүнд цөөн боловч илэрч олджээ. Тухайн үеийн монголчуудын хот суурины ор үлдэгдэл болон булш оршуулга гэсэн үндсэн хоёр дурсгалаас энэ үеийн хөгжмийн олдвор илэрч мэдэгдсэн байна. Тухайлбал, Монголын эзэнт гүрний нийслэл Хархорумын өмнөд хаалганы орчимд буюу 1948-1949 оны Монгол-Зөвлөлтийн хамтарсан түүх, угсаатны зүйн шинжилгээний ангийн малтлагын талбайгаас холгүй газраас 1950 онд анжис, тэрэгний цөн, гилбэр зэрэг зүйлстэй төмөр эдлэлийн даршийг санамсаргүй тохиолдлоор

олсны дотор давхарлаж тавьсан хос хүрэл хонх гарсан ажээ (Наваан 1962, 63-64). Үүний гаднах нь мөрөн дээрээ гүвгэр судалтай энгийн хийцтэй 17,5 см өндөр, 16 см голчтой бол харин доторх нь гадаргуу дээрээ үсэг тэмдэг, элдэв зураг чимэг бүхий нэлээд уран хийцтэй. Аль аль нь төмөр хэлтэй байжээ. Ийм том хэмжээтэй, уран хийцтэй биш боловч дохио тэмдэг гаргах чадалтай, орой дээрээ юманд хадаж тогтоох, оосорлож сүвлэх зориулалт бүхий тусгай сэнжтэй жижиг хүрэл хонх Хархорумын хойд хэсэгт орших барилгын нэгэн цогцолбор дурсгалыг сүүлийн үед шинжлэн судлах явцад гарсан байна (Батбаяр 2022, 79).



Зураг 14. Хархорумын малтлагаас олдсон ясан шүгэл.
XIII-XIV зуун, Өвөрхангай аймаг, Хархорин сум

Түүнээс гадна Монгол-Германы хамтарсан Хархорум төслийн хүрээнд 2000 оноос Хархорумын гар урчууд, худалдаачдын хороололд хийсэн малтлагаас тус хотын оршин суугчидтай холбоотой төрөл бүрийн эд өлгийн зүйлийг олон мянгаар илрүүлж олсны дотор хөгжмийн зэмсгийн зүйлд хамааруулан үзэж болохуйц олдворын зүйл

байсан нь нэн сонирхолтой юм. Энэ нь халиун бугын ясаар хийсэн, хөндий хонгио бөгөөд нэг тал нарийн шувтгар, нөгөө тал нь өргөн бүдүүн. Хонгионы нарийн үзүүр талд ташуу нүхтэй бол өргөн талын ирмэг хөвөөг тойрсон долоон нүхтэй. Голч 1,6 см, 4 см урт хэмжээтэй болохыг судлаачид тодорхойлсны зэрэгцээ ямар нэгэн зүйлийн бариул

хэмээн үзжээ (Pohl 2010, 144, 146). Харин энэ эдлэл нь хэлбэр, хэмжээ, хийцийн онцлогоороо шүгэл, шовшууртай төстэй байна (Зураг 14).



Зураг 15. Ясан шүгэл.
XIII-XIV зуун, Сүхбаатар аймаг, Онгон сум

Энэ дашрамд дурдахад, Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Таван толгойд орших Монголын эзэнт гүрний үеийн булш оршуулгыг МУИС-ийн профессор Д.Наваан анх илрүүлж 2004, 2005, 2007 онуудад энгийн иргэдийн 5, язгууртан дээдсийн 9 булшийг малтаж эрдэм шинжилгээний ховор үнэтэй олон эх хэрэглэгдэхүүнийг нээж олсон байна. Үүний дотор, 2004 онд малтан шинжилсэн 2-р булшнаас ясан шүгэл илэрчээ (Зураг 15). Эдгээр булшны олдворууд XIII-XIV зууны монголчуудын хувцас, эд хэрэглэл, шашин шүтлэг, зан суртахууны олон зүйлийг тодруулан судлахад үнэлж баршгүй ач холбогдолтой биет хэрэглэгдэхүүн юм (Эрдэнэбат 2011, 31).

Ийнхүү Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулсан археологийн судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд, хөгжмийн зэмсэгтэй холбогдож болох сэдэв агууламж бүхий Шинэ чулуун зэвсгийн үеэс Хүрлийн үе хүртэлх хугацаанд хамаарах хадны сүг зургууд, Хүрэл зэвсгийн үед холбогдох 2 ясан шүгэл, Хүннү хэл хуур, Түрэгийн босоо ятга, Уйгурын хүрэл хонх, Монголын эзэнт гүрний үеийн ясан шүгэл, их бага хүрэл хонхнууд зэрэг Монголын эртний түүхэн үеүдэд холбогдох хэдэн зүйлийн хөгжмийн зэмсэг илэрч олдсон байна. Манай улсын археологийн дурсгалаас олдсон эдгээр хөгжмийн зэмсгийн холбогдолт олдворууд нь одоогийн монгол нутагт оршин тогтнож явсан эртний нүүдэлчдийн оюуны соёлын хөгжлийг илтгэн харуулахын зэрэгцээ хөгжмийн зэмсгийн төрөл зүйл, түүхэн уламжлал, хөгжлийг гэрчлэн харуулах биет баримт хэрэглэгдэхүүн болох нь илэрхий байна.

НОМ ЗҮЙ

Батбаяр, Т. *Хархорумын несторын шашинтны дурсгалын археологийн судалгаа*. “Монголын археологийн шинэ судалгаа” - VII. Редактор У.Эрдэнэбат. УБ., 2022.

Батболд, Н. Хадны зураг дахь оршуулгын зан үйлтэй холбогдох өвөрмөц дүрслэлийн тухай. *Хүрэл, түрүү төмрийн үе ба хүннүгийн өмнөх соёлын судалгааны асуудал*. Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2014: 66.

Батсайхан, З. *Хүннү (Археологи, угсаатны зүй, түүх)*. Редактор Д.Баяр. УБ., 2002.

Баттулга, Ц. Жаргалант хайрхны хөгжмийн зэмсэг дээрх эртний бичээс. - Талын морьтон дайчдын өв соёл: VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн. УБ., 2014: 174-176.

Баяндэлгэр, Ч., Баярсайхан, Ж., Хюл, Ж.Л. Замбын үзүүр хэмээх газраас олдсон ясан шүгэлний тухай. *Музей судлал*. Том. XXIII, Fasc. 4, УБ., 2022: 36-43.

Ганпүрэв, Д. Алтай ятгын хөгжмийн судалгаа ба дахин нутагшуулах асуудалд. - Талын морьтон дайчдын өв соёл: VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн. УБ., 2014: 189.

Наваан, Д. Клад железных предметов из Хара-Хорина. *Монгольский археологический сборник*. М., 1962: 63-64.

Новгородова, Э.А. *Древняя Монголия (Некоторые проблемы хронологии и этнокультурной истории)*. М., 1989.

Төрбат, Ц. Евразийн зүүн хэсгийн эртний нүүдэлчдийн археологийн дурсгалаас илэрсэн хэл хуурууд. *Археологийн судлал*. Том. XXXVI, Fasc. 11, УБ., 2017: 169-180.

Төрбат, Ц., Батсүх, Д., Батбаяр, Т., Баярхүү, Н., Идэрхангай, Т. Монгол Алтайгаас илэрсэн хадны оршуулгууд (урьдчилсан үр дүн). *Studia Archaeologica*. Том. XXVI (VI), Fasc. 14, УБ., 2008: 279.

Цэвээндорж, Д. Шинээр олдсон хадны зосон зураг. *Археологийн судлал*. Том. VII, Fasc. 4, УБ., 1977: 29-38.

Цэвээндорж, Д. Монголын археологи, урлагийн ховор шинэ олдворууд. *Археологийн судлал*. Том. I (XXI), Fasc. 4, УБ., 2003: 52.

Цэвээндорж, Д. Морин толгойн булшнаас олдсон “Хүннү хэл хуур”. - Д.Цэвээндорж. *Монголын археологийн судалгаа (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл) 1983-1992*. Боть II. УБ., 2003: 293-301.

Цэрэндагва, Я. Шинээр илрүүлсэн хадны зургийн дурсгал дахь зарим өвөрмөц дүрслэл. *Орос, Монгол, Хятадын хил залгаа бүс нутгийн эртний нийгмүүдийн соёлын хувьсал ба харилцан нөлөөлөл: Төв Ази ба Умард Хятадын хадны зураг*. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2017: 101.

Энхтөр, А., Цэрэндагва, Я., Хүрэлсүх, С., Мөнхбаяр, Л., Эрдэнэ, Б., Буянхишиг, Ц., Дашдорж, Б. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Уньт

багаас Хөвсгөл аймгийн Тариалан сумын чиглэлд тавих 88 км авто замын трассын дагууд хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын тайлан. ШУА-ийн АХГБСХ. УБ., 2011.

Эрдэнэбат, У. Таван толгойн монголын үеийн булш оршуулгын дурсгал. - “*Онгон нутгийн өв соёл*” үзэсгэлэнгийн каталоги. Зохиогч У.Эрдэнэбат, Ц.Төрбат. УБ., 2011: 31.

Эрдэнэбат, У., Батбаяр, Т. Монгол-Германы Орхон экспедицийн 2018 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан. ШУА-ийн АХГБСХ. УБ., 2019.

Эрдэнэбат, У., Франкен, К., Батбаяр, Т., Рооланд, Х. Уйгурын нийслэл Хар балгасанд 2018 онд Монгол Германы Орхон экспедицийн хийсэн малтлага судалгаа. *Монголын археологи-2018*. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2019: 254-260.

Bemmann, J. (Hrgs.). *Steppenkreier: Reiternomaden des 7.-14. Jahrhunderts aus der Mongolei*. Bonn: LVR-LandesMuseum Bonn, 2012: 380, 385.

Jacobson-Tepfer, E. Die Jagdszene auf dem Musikinstrument. - *Steppenkreier: Reiternomaden des 7.-14. Jahrhunderts aus der Mongolei*. J. Bemmann (Hrgs.). Bonn: LVR-LandesMuseum Bonn, 2012: 158.

Pohl, E. KAR-2, Catalogue of Artefacts I: Processed Bones (with Faunal Analysis by Angela von den Driesch and Joris Peters). In: *Mongolian-German Karakorum Expedition. Volume 1: Excavations in the Craftsmen Quarter at the main Road*. Forschungen zur Archäologie Ausereuropaeischer Kulturen. Bd. 8, Wiesbaden, 2010: 144, 146.

Shulz, S. Die Altai-Harfe-Eine Rekonstruktion. - *Steppenkreier: Reiternomaden des 7.-14. Jahrhunderts aus der Mongolei*. J. Bemmann (Hrgs.). Bonn: LVR-LandesMuseum Bonn, 2012: 147.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>